

АСГАТ СУМЫН 2021 ОНЫ 6 САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 06 сарын 25-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэйгээр тэмцэх, бэтлгэл бэлэн байдлыг хангуулах, тусгаарлах, гэрийн ажиглалтыг сайжруулан сумын шуурхай штабыг ажиллуулан хөдөлгөөнт 6. Баруун-Урт, Эрдэнэцагаан чиглэлийн замд 2 гэр барьж, суурийн постыг 24 цагаар тасралтгүй ажиллуулж байна. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын онцгой комисс, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын Сумын онцгой комисс, Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн сайдын албан даалгавар, тушаалын хэрэгжилт, тусгаарлан эмчлэх байр, тусгаарлан ажиглах байрны тохижилт, ковидын хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариа, ариутгалын бодисын нөөц, хүн хүчний бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Сумын Засаг даргын захирамжаар 22-27 хүртэлх хугацаанд сумын хэмжээнд тэг зогсолт хийгээд байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын хэмжээнд COVID-19 вирус гарсантай холбогдуулан хөдөлгөөнт пост болон хариуцлагтай жижүүр ажилласан. Коронавирустай холбоотой 6 сарын гүйцэтгэлээр гүйцэтгэл нь

1. ЗДТГ-ын тээвэр шатахуун зардал 6,357,350 төгрөгийн 2021-оны 04 сарын 01 –нээс 05 сарын 30 хүртэлх 2 сарын өр үүссэн. Үүнийг аймгийн төрийн сангийн төсвийн мэргэжилтэнтэй яриж урсгал засварын зардал дээр байсан 10,000,000 сая төгрөгийг хуваарь өөрчлөлт оруулж сангийн яаманд татуулан гамшигийн зардалд тавьж постны тээвэр шатахууны зардлын өрийг барагдуулан ажиллалаа. Мөн нэн түрүүнд шаардагдах СОК –ын нөөцийг бүрдүүлэн боломжит зардлаас гаргаж байна. Одоогийн байдлаар ариутгал халдваргүйжүүлэлт ажиглалтын байрны хоол хүнс бараа материалын бүрдүүлж ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль орчин:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр: Ахмат настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 ахмадын төсөл

дэмжигдэж тус бүр 2 сая төгрөгийн санхүүжилтийн авсан. Малжуулах хөвөлбөрт 1 залуу малчин өрх 5 сая төгрөг, ХБИ дэмжих хөтөлбөрт 1 иргэн 3 сая төгрөг, ОНОТХҮ-ний төсөлд 4 өрх 2 бүлэг болон тус бүр сая төгрөгийн санхүүжилтыг авсан. Бүлгийн ногоонд зорилтод 9 өрхийн гишүүдийг бүлэг болгон Асгат дөхөм ХХК төмсний үрийг гарган тариалалт хийлгэсэн. Нийтийг хамарсан ажилд ногоон байгууламж төсөл дэмжигдэж 10 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2021.06.23ний байдлаар 418 хүнээс коронавирусын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийхэд 410 сөрөг, 8 сул эерэг тохиолдол гарсан. Уг тохиолдлыг Дорнод аймгийн БОЭТ, АНЭ-т 35 PCR шинжилгээнд хүргэсэн. Коронавирусын халдвартай 2 иргэн батлагдан АНЭ-т хэвтэн эмчлүүлж байна. Батлагдсан тохиолдлын ойрын 26, дам 67 хавьтал нийт 92 иргэн гэрийн тусгаарлалтанд байна.

Тус сумын хэмжээнд давхардсан тоогоор иргэнийг 386 гэрийн ажиглалтанд авсан бөгөөд тухайн иргэдийг гэрийн ажиглалтанд орсон өдрөөс нь эхлэн сумын онцгой комиссын гишүүд, ЭМТ-ийн гэрийн ажиглалт хариуцсан мэргэжилтэнүүд гэрийнхэнд нь анхааруулга, иргэнд зөвлөмжийг өгүүлж тандалтыг хийлгэж ажилласан.

2021.06.23ний байдлаар 2441 хүнд вакцин хийгээд байна.

Боловсролын чиглэлээр:

ЕБСургууль 2020-2021 оны хичээлийн жилд суурь боловсролыг 21 суралцагч амжилттай төгсөж 15 суралцагч 10 дугаар анги 7 суралцагч МСҮ-ийн төвд суралцах хүсэл гаргасан байна. “ А “ үнэлгээтэй суралцсан 9 суралцагчдад сургуулийн зүгээс “ Батламж “ гардуулсан болно. Багш нар болон удирдах ажилтан зарим ажилчид онлайн сургалтанд тогтмол хамрагдан ажиллаж байна.

Цэцэрлэг:Байгууллагынхаа гадна тохижилтонд анхаарч багш ажилчидтайгаа хамтран хүнсний агуулахын барилгын гадна эмульс татах, цэцгийн мандал хийх зэрэг ажлуудыг хамтран хийж гүйцэтгэлээ.

Хуучин ногооны талбайгаа сунгаж, төмс, лууван, огурцы, манжин зэрэг өргөн хэрэглээний хүнсний ногоог хамт олонтойгоо тарьж усалгааг 7 хоногт 3 удаа хийж байна.

Соёлын талаар:

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмж, Сумын Онцгой комиссын шийдвэр, зэрэг мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэн өдөр бүр 3 удаа суурин узелиэр иргэд олон нийтэд хүргэж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ЯДАМЖАВ.